MERIT

Mongolia: Enhancing Resource Management through Institutional Transformation

Гэрээлэн гүйцэтгүүлэх

IPAC IAPC

MERIT

Ярилцах сэдвүүд

1. Гэрээлэн гүйцэтгүүлэх гэж юу вэ? Түүний ашиг тус ?

2. Үйлчилгээг илүү үр дүнтэй хүргэж, үнэ цэнийг нь нэмэгдүүлэх зарим шинэлэг загварууд

3. Гэрээлэн гүйцэтгүүлэх арга ажиллагаа

4. Хоёр кейсийн судалгаа

Гэрээлэн гүйцэтгүүлэх гэж юу вэ?

Энэ бол тухайн нутаг дэвсгэрийн оршин суугч, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, түүнийг хангахад шаардлагатай байгаа төрийн үйлчилгээг тодорхойлж, улмаар байгаа нөөц бололцоог дээд зэргээр ашиглах замаар тэрхүү үйлчилгээг хүргэх ононвчтой механизмыг сонгож олох үйл явц мөн.

Засгийн газрын хүрээлэн

Дэлхий дахинд гэрээлэн гүйцэтгүүлэх аргыг өргөн хэрэглэх болсоны учир

Иргэдийн хүлээлт нэмэгдсэн

+

Иргэдийн хэрэгцээ өссөн

+

Хөрөнгө санхүүгийн хүндрэл

+

Технологийн өөрчлөлт

Их Британи, Австралид гэрээлэн гүйцэтгүүлэх аргыг хэрэглэж байгаа нь

Манай улсад иргэдэд үзүүлэх үйлчилгээний үр дүнг сайжруулж, улам бүр хомсдож буй хөрөнгө мөнгөний өгөөжийг нэмэгдүүлж чадахуйц тийм үр ашигтай гэрээлэн гүйцэтгэгчид урьд урьдаас илүү их хэрэгтэй байна.

Их Британи улсын ЗГ-ын гишүүн

... энэ бол бодлого гаргагчдаасс аливаа хөтөлбөр, бодлогыг батлахдаа тэдгээр нь зорьсон үр дүнгээ заавал өгөх явдлыг баталгаажуулахад чиглэсэн арга хэрэгсэл юм.

Австралийн Үндэсний Аудитын Комисс

Гэрээлэн гүйцэтгүүлэх аргын ашиг тус

1. Үйлчилгээ хүргэх загвар ба суваг дамжлагыг шинэчилснээр эцсийн хэрэглэгчийг тэргүүн эгнээнд авчрах

2. Төрийн үйлчилгээний зах зээлийг түүний үр дүн, үнэлэмжийг нэмэгдүүлэх үүднээс цэгцтэй болгох

3. Гуравдагч этгээдийн з**ах зээлийн үүрэг оролцоо/ гэрээлэлтийг сайжруулах**

Жишээ: Онтарио муж улсын нийтийн үйлчилгээний зах зээл

Онтарио муж улсын Засгийн газрын зардлын 85 орчим хувийг төлбөр шилжүүлэх үйл ажиллагаагаар дамжуулан олгодог

23,000 гаруй төлбөр шилжүүлэх гэрээтэй

1,900 орон тооны ажилтан

Төрийн үйлчилгээний зарим зах зээлийн өнөөгийн байдал



Гэрээлэн гүйцэтгүүлэх: Нийтлэг асуудлууд

1. Ажлын үр дүнг урьдчилан тодорхойлох
2. Эрэлт хэрэгцээг эрүүл ухаанаар, баримт нотолгоонд тулгуурлан үнэлэх
3. Хөтөлбөрийн зорилгууд, тэргүүлэх чиглэлүүд, үүргүүдийн (хэн юу хийх вэ) талаар шийдвэр гаргадаа өнөөгийн загвар, үзэл сурталд агностик /хэвшмэл бус/ үүднээс хандах
4. Үйлчилгээг хүргэх загварыг хэрэглэгчид болон үйлчилгээ үзүүлэгч нартай хамтран боловсруулж гаргах
5. Засгийн газар нь төрийн үйлчилгээний зах зээлд хяналт тавигч зохицуулагч байх

Ямар ялгаатай вэ?

- Үйлчилгээний тэгшитгэлийн нийлүүлэлт гэсэн хэсгийн оронд эрэлт талд анхаарлаа төвлөрүүлж үйлчилгээ үзүүлэх бүх үйл явцын турш хэрэглэгчийг баримжаалж хамтран ажиллана.
- Бодлого ба хүргэлтийг нягт уялдуулна.
- Үйлчилгээг төрийн байгууллага өөрөө биш харин гуравдагч этгээдээр гүйцэтгүүлдэг ялгаанаас гадна системийн дизайн, зохицуулалтад засгийн газар голлох үүрэг гүйцэтгэнэ.
- Шийдлийг хамтран боловсруулах, үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчийн үүрэг оролцоог тасралтгүй хангана.

Гэрээлэн гүйцэтгүүлэх аргын гол ба бусад зарчмууд

Олон янз байдал
нь олон нийтийн үйлчилгээнд инновацийг сайжруулж, илүү их үнэ цэнийг бий болгодог.

Холимог эдийн засагт төрийн үйлчилгээг төрийн болон төрийн бус, мөн хувийн хэвшлийн нийлүүлэгч нар үзүүлдэг ба санхүүжилтийг ихэвчлэн төлбөр шилжүүлэх замаар хийдэг.

ГЭРЭЭЛЭН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ

Үйлчилгээ үзүүлэхэд **ӨРСӨЛДӨӨНТ БАЙДАЛ** байх нь чухал. Хэрэв үйлчилгээ үзүүлэгч нь амжилт олохгүй бол тэрээр өрсөлдөөнд орох эсвэл өөр гэрээлэгчээр солигдох бодит аюултай байх хэрэгтэй.

Зах зээл дахь хяналт зохицуулалт
нь холимог эдийн засагт үнэ цэнэ, хүссэн үр дүнд хүргэхийн тулд шаардлагатай байдаг.

Өрсөлдөөнт байдал

Төрийн үйлчилгээ үзүүлэгчдийн хүрэх төвшин тодорхой байх ба хангаагүй тохиолдолд түүний оронд өөр байгууллага авч ажиллуулах эрсдэлтэй тулгардаг.

Өрсөлдөөнт байдал дараахь байдлаар хангагдана. Үүнд:

- Аль нэгэн үйлчилгээ үзүүлэгч нь гарсан алдаа дутагдлаа засаж залруулах нөхцөл боломж олгосоор байтал хүлээсэн үүргээ биелүүлэхгүй бол тэдний оронд бусдыг авч ажиллуулна гэдгийг ойлгож идэвхи санаачлагатай ажиллах.
- Бүх талууд гүйцэтгэлийн болзол шаардлагыг ойлгосон байх.
- Гүйцэтгэлийг хянах хараат бус, бие даасан механизмтай байх.
- Хагас дутуу хийсэн зүйлээ хийж гүйцээх, хэрэв тэгэхгүй бол оронд нь өөр байгууллагыг сонгон авч ажиллуулах талаар бүгд нэг ижил ойлголттой байх.

Зах зээлийн хяналт зохицуулалт

Төрийн үйлчилгээнд зах зээлийн механизм голлох үүрэг гүйцэтгэх ба харин ЗГ түүнийг ерөнхийд нь зохицуулна

Зах зээлийг хянах, зохицуулах ажиллагаа дараахь байдлаар явагдана. Үүнд:

- Үйлчилгээ үзүүлэх эрэлт хэрэгцээ, зорилго зорилт, хэрэгжүүлэх нөхцөл боломжийн талаар хэрэглэгч болон үйлчилгээ хүргэгч нартай ойр дөт хамтран ажиллах.
- “Тоглоомын дүрмийг” тогтоож, үйлчилгээ хүргэгч болон хэрэглэгчдийн зүгээс түүнд уян хатан зохицож ажиллах боломжийг олгох.
- Зах зээл хэрхэн хувьсаж өөрчлөгдөж байгаад хяналт тавих.
- Системийг ерөнхийд нь залуурдах зорилгод нийцүлэн тоглоомын дүрэмд зохих тохируулга хийх.
- Дээрх чиг үүргийг үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай нөөц, ур чадварыг бий болгох.


Гэрээлэн гүйцэтгүүлэх загварууд

Энэ хүснэгтэнд төрийн үйлчилгээг гэрээгээр хүргэх загваруудыг судлаж үзсэний дагуу ЗГ-н болон гуравдагч талын үйлчилгээ үзүүлэгч нарын үүргийг нэгтгэн харуулсан.

	Төрийн байгууллагаар үйлчилгээ үзүүлэх		Аутсорсинг буюу өөр байгууллага үйлчилгээ хүргэх		Ваучер буюу Эрхийн бичиг		Нийгмийн үйлчилгээний бонд		Нэгтгэсэн / Ерөнхий гэрээ		Хамтарсан компани		Хамтын сан	
	Засгийн газар	З-дагч тал	Засгийн газар	З-дагч тал	Засгийн газар	З-дагч тал	Засгийн газар	З-дагч тал	Засгийн газар	З-дагч тал	Засгийн газар	З-дагч тал	Засгийн газар	З-дагч тал
Бодлого тодорхойлох	✓		✓		✓		✓		✓		✓		✓	
Зохицуулах	✓		✓		✓			✓	✓	✓	✓		✓	
Хүргэх	✓			✓		✓		✓		✓	✓	✓		✓
Тохируулах	✓		✓		✓		✓		✓	✓	✓		✓	
Санхүүжүүлэх	✓		✓	✓	✓			✓	✓	✓	✓	✓	✓	✓

Гэрээлэн гүйцэтгүүлэх арга ажиллагааны хэрэгжилт

KPMG-ийн гэрээлэн гүйцэтгүүлэх аргачлал нь үйлчилгээ үзүүлэгч/хэрэглэгчийн оролцоотойгоор төлөвлөсөн үр дүнд хүрэх хамгийн сайн үйлчилгээг үзүүлэх нөхцөл боломжийг тодорхойлохын тулд дараахь долоон алхамыг ашигладаг. Алхам бүр нь мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, оновчтой шийдлийг тодорхойлох иж бүрэн арга хэрэгслүүдээс бүрдэнэ.







kpmg.ca



© 2016 KPMG LLP, a Canadian limited liability partnership and a member firm of the KPMG network of independent member firms affiliated with KPMG International Cooperative ("KPMG International"), a Swiss entity. All rights reserved. The KPMG name and logo are registered trademarks or trademarks of KPMG International.

The information contained herein is of a general nature and is not intended to address the circumstances of any particular individual or entity. Although we endeavour to provide accurate and timely information, there can be no guarantee that such information is accurate as of the date it is received or that it will continue to be accurate in the future. No one should act on such information without appropriate professional advice after a thorough examination of the particular situation.